



**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

14251 Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, II хороо, Чингисийн өргөн чөлөө 11,  
Утас: 70112333, Факс: (976-11) 31-23-15  
E-mail: [info@mrt.gov.mn](mailto:info@mrt.gov.mn), <http://www.mrt.gov.mn>

“ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ”  
ТӨХК-ИЙН ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  
М.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

2016.04.09 № 038/07/04/08

**Завод их засварын тухай**

Танай байгууллагын 2016.03.16-ны өдрийн 02/1240 дугаартай албан хүсэлтийг судлан үзэж, дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна.

ТЭМ2 серийн илчит тэрэгний завод их засварын нөхцөл:

1. ТЭМ2 серийн илчит тэргэнд завод их засвар хийх эрх бүхий байгууллага Монгол Улсад одоогоор байхгүй байна;
2. ТЭМ2 серийн илчит тэргэнд ОХУ-ын завод их засварын үйлдвэрт КР-2/Завод их засвар/ хийж гүйцэтгэдэг;
3. КР-2 их засвар нь КР-1 засвараас ялгагдах онцлог нь бүх цахилгаан машинуудыг засварлан, цахилгаан хэлхээг шинээр солин, ашиглалтын хугацааг сунгадаг онцлогтой;
4. Завод их засварын дүрмийн дагуу техникийн бүх бичиг баримтыг үйлдэж, туршилт хийн баталгаажуулан техникийн паспорт дээр бичигдсэн байх шаардлагатай.

Дүгнэлт, зөвөлгөө:

1. ТЭМ2-1280 илчит тэрэгний хувьд ашиглалтын хугацаа дууссан учир КР-2 засварыг ОХУ-ын завод их засварын эрх бүхий, албан ёсны, туршлагатай байгууллагаар хийлгэх нь зүйтэй;
2. ТЭМ2-1280 илчит тэрэг 2013 оны 01 сараас хөдөлгөөнд оролцоогүй учир бүх эд ангийн баталгаажуулалтын хугацаа дууссан байгаа тул аюулгүй байдалд онцгой анхаарч “УБТЗ” ХНН-ийн Улаанбаатар татах хэсэгт ТО-6 үйлчилгээгээр завод засварт бэлдүүлэх шаардлагатай;
3. Илчит тэргийг засварт бэлдэх, засварлах, засвараас буцаан авчирхад хугацаа их зарцуулдаг учир 4, 5-р сард багтаан КР-2 засварт явуулах нь зүйтэй;
4. Илчит тэргийг КР-2 засварт явуулахдаа Монгол Улсын Төмөр замын тээврийн тухай хууль, Төмөр замын нийтлэг багц дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийг баримтлах нь зүйтэй.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ЗАМ, ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН  
ХЭЛТСИЙН ЗҮТГҮҮР, МАШИН МЕХАНИЗМЫН  
ХЯНАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН,  
УЛСЫН БАЙЦААГЧ



Х.ИТГЭЛТ